



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2015 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот


Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Өргөдлийн байнгын хорооноос **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Засгийн газрын “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” 2011 оны 175 дугаар тогтоол Газрын тухай, Ашигт малтмалын тухай хууль тогтоомжид нийцэхгүй байх тул хуульд нийцүүлэн өөрчлөх, эсхүл хүчингүй болгохыг Монгол Улсын Засгийн газар /М.Сайханбилэг/-т чиглэл болгосугай.

2. Тогтоолын биелэлтийг 2015 оны хаврын чуулганы хугацаанд багтаан тус Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /М.Сайханбилэг/, Уул уурхайн яам /Р.Жигжид/-нд тус тус даалгасугай.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



О.БААСАНХҮҮ